

1921 ОНЫ МОНГОЛЫН ХУВЬСГАЛЫН ҮЕ ДЭХЬ Д.БОДООГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭМЭН ТОДРУУЛАХ НЬ

Н.Хишигт

Шинжлэх Ухааны Академи. Түүхийн хүрээлэн

Өгүүллийн товч: Тус өгүүлэлд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын түүхэнд эзлэх байр суурийг тодруулах зорилгоор түүний үйл ажиллагааг Консулын бүлгийг анх үүсгэн байгуулж удирдах болсон цагаас МАН-ыг байгуулахад хүчин зүтгэсэн, улмаар МАН-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орлцон ЗОУ- очсон, тэндээс "онц үүрэг" хүлээн Д.Догсомын хамтаар Монгол нутагтаа ирж, цагийн байдал, хэргийн чухалд зохицуулан ажилласан 1921 оны гуравдугаар сарын дунд үе хүртэлх он цагийн хүрээнд хураангуйлан авч үзэж, онцлог содон талыг харуулж, зарим нэгэн үйл явдлын он цагийг тодотгон, шинэ баримт мэдээг судлагааны эргэлтэд оруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг. Д.Бодоо, Консулын бүлгийг үүсгэн удирдагч, намын бичиг баримтыг боловсруулагч, МАН-ын төлөөлөгч.

Д.Бодоо бол монголчууд тусгаар байдлаа алдаж, харийн эрхшээлд дахин орох аюул тулгарсан цаг мөчид төр түмнийхээ төлөө зориглон босогчдын манлайд байж, их хэргийг бүтээгээд өөрийн оюун ухаан, итгэл зүтгэлээрээ байгуулалцсан төр засгийнхаа хүнд цаазыг хүлээн хилсээр хороогдсон нэгэн билээ. Хилс хэрэг түүнийг түүхийн худаснаа хараар бичих үнэнийг гажуудуулах уг сурвалж болсон юм. Ганц Д.Бодоог бус, өрөөс 1921 оны хувьсгалын хэргийг үүсгэн санаачилж, удирдан зохион байгуулсан эх орончид, намын нөхдийн нэг хэдийг нь магтан өргөмжилж, нөгөө заримыг нь үгүйсгэн орхигдуулж байсан нь түүхийн тодорхой үеийн улс төрийн бодлого, үзэл суртлын нөлөө дарамтаас улбаалсан түүх бичлэгийн алдаа байлаа. Гэвч тэрхүү алдааг засч залруулах цаг ардчилал шинэчлэлийн ач буянаар монголчуудын үндэсний ухамсар мэдрэмж сэргэн, эхн түүхээсээ туршлага сургамжжийг эрэлхийлэх болсон 1990-ээд оны эхээр ирж, Монголын түүхийн судалгаанд шинэ үеийг нээсэн билээ. Чухам энэ үеэс түүхэн зүтгэнэлтнүүдийн намтрын судалгаахамрах хүрээ, сэдвийн хувьд адиваа нэгэн хязгаарлалтад үл автан өргөжсөнөөр ХХ зууны Монголын улс төрийн түүхийн нилээд асуудлыг, түүний дотор 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын удирдагчдын талаар ч тодруулан тодрууланг үнэлэх боломжийг олгосон юм. Энэ хүрээнд анх түрүүнд судлагдсан түүхэн зүтгэлтний нэг бол Л.Бодоо мөн.

Эдүгээ Д.Бодоогийн намтар, үйл ажиллагааг сэргээн судалсан хэд хэдэн ном бүтээл гарч¹, судлагаа үргэлжилсээр буйд өчүүхэн төдий ч нэмэр болгох днээс түүний 1920-1921 оны эхэн үеийн үйл ажиллагааг Консулын бүлгийг үүсгэн байгуулсан цагаас МАН-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж ЗОУ-д очсон, тэндээс "онцгой чухал үүрэг" хүлээн Монгол нутагтаа ирж, цагийн байдалд зохицон ажилласан он цагийн хүрээнд хураангуйлан өгүүлж, онцлог содон талыг баримт түшин тодруулахыг хичээлээ.

Нэг. Д.Бодоогоос Консулын бүлгийг үүсгэн байгуулсан талаар түүний хамтран зүтгэгчдийн дурсамжаас эхлээд түүхчид, судлаачдын бүтээлд бичиж тэмдэглэсээр ирсэн хэдий ч, үндэсний ардчилсан хувьсгалыг удирдсан улс төрийн хүчний эх үүсвэр байсан нууц бүлгэмүүдийг үүсгэн санаачлагчдын асуудал Д.Бодоо, С.Данзан нарын нэр төрийг албан ёсоор сэргээсэн 1990-ээд

¹ Л.Бат-Очир. "Д.Бодоо сайд үзэл бодол, үйлс". УБ., 1991., мөн түүний. Д.Бодоогийн тухай нэмэн өгүүлэх нь - //Л.Бат-Очир. Түүхэн үнэний эрэлд. Судалгааны өгүүллийн түүвэр // УБ., 1999. т.318- 344., "Догсомын Бодоо. 1885-1922. (Хэлсэн, бичсэн зүйлийн түүвэр)". УБ., 2001.

оны эхнээс л түүх бичлэгт нэг мөр болон цэгцэрч, намын бодлого, цагийн өнгө аяст автагдан үнэнийг гуйвуулсан түүхийн алдааг залруулсан билээ.

“Ардын нам” хэмээн өөрсдийнх нь нэрлэж байсан Консулын бүлгийн үүсгэн санаачлагч, удирдагч нь чухамхүү Д.Бодоо байсныг багахан тодруулахыг оролдвоос:

Консулын бүлэг байгуулагдах үндсэн шалтгаан нь тухайн үеийн Монголын байдал болох хэдий ч, түүнийг санаачлагч нь чухамхүү Д.Бодоо болоход нөлөөлсөн хүчин зүйл нь түүний Хүрээн дэхь оросуудтай тогтоосон хэлхээ холбоо байсан хэмээн үзэх үндэстэй. Учир нь эрдэм чадвар, эрхлэх ажлын¹ хувиар Хүрээнд оршин сууж байсан оросуудтай танил болж, тэдний дунд нэр хүндийг олсон Д.Бодоо Орос оронд болж байсан үйл явдлын талаар зөвхөн сонсож мэдээд зогсохгүй, түүнээс үлгэр жишээ авч, улс орноо хятад цэргийн дарангуйллаас ангижруулах арга замыг эрэлхийлэхдээ санаа нэгт нөхдийг өөртөө татан нэгтгэх болсон гэлтэй. Тэр тусмаа түүнийг дагаж дэмжсэн “хуурай дүү” бөгөөд “хэлмэрч” нь болох Х.Чойбалсан Оросын Эрхүү хотноо суралцсан; нутаг нэгтэй, дотнын нөхөр Д.Чагдаржав нь Орос Хиагт-Троицкосавскийн зээлд арилжаа эрхэлж, Англи, Итали, Польш, Орос газар зэрэг орноор гурван жил илүү яваад ирсэн нэгэн байсан²; бүлэг үүсгэхэд нэгдсэн Д.Лосол мөн л Бээжин, Москва Петербург хотуудаар аялж явсан³ гэх зэргээр хөрш оронд очсон, сурсан хүмүүс байсан нь сонирхолтой бөгөөд тэдний тэрхүү байдал нь бүлгийн дотор үзэл санааны нэгдэл буй болоход зохих нөлөө үзүүлсэн болов уу. Тийнхүү Консулын бүлгийг байгуулсанаас хойшхи Д.Бодоогийн үйл ажиллагаанд дараах зүйлүүдийг онцолж болмоор байна. Үүнд:

а. Д.Бодоо нь Хүрээний бүлэгтэй холбоо тогтоох, түүнтэй нэгдэх явдлыг анхлан санаачилсан байна. Энэ тухай “...хувьсгалын явж ирсэн үнэн баримттай замыг биеэр явсан ба бичиг материал зэргээс түүвэрлэн авч ... магад баримттайгаар дахин нээж тодруулах”⁴ зорилгоор бичигдсэн Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын зохиолд нилээд тодорхой дурдсанд тулгуурлавал: Д.Бодоо нь өөрсөдтэй нь адил санаа зорилго бүхий хүмүүс буйг сонсож дуулмагц эхлээд С.Данзантай, дараа удаад нь Д.Догсом, Ө.Дэндэв, Д.Сүхбаатар нартай тус тусад нь уулзан, улс төрийн явдлыг харилцан ярилцаж, байр байдлыг нь тандан, нилээд хэдэн хүн болохыг магад мэдсэний эцэст тэдгээр нөхөдтэй нэгдэж, хамтрах санал гаргасаныг нь О.Жамъян нар ихэд дэмжсэн⁵-ээр бодит үйл хэрэг болжээ.

б. Тэрээр өөрийн гэрт намын нөхдийг хуралдуулдаг байсан бөгөөд чингэхдээ нууц байдлыг хадгалах үүднээс гэрийг хол нүүлгэн барих зэргээр намын нөхдийн байнгын үйл ажиллагааг хангах талаар боломжтой бүхий л арга хэмжээг авч байснаас үзвэл Д.Бодоо нь хятад цэргийн хатуу чанд мөрдлөгийн үед эрсдэж баригдахыг үл хайхран үзэл бодол, үйл ажил, амьдрал ахуй бүхий л зүйлээ эрх чөлөөний тэмцэлд зориулсан гэж үзэж болно.

Бодоо бол Монголын улс төрийн анхны намын тамгыг бүтээсэн нэгэн билээ. Тэрбээр тамгыг сийлж байхдаа “... Монголын олон түмэн ядуу буурай

¹ Тэрээр Шавийн яамнаас гарсаны дараагаар Оросын консулын дэргэдэх орчуулагчийн сургуулийн монгол бичгийн багш, Консулын газрын монгол бичээч, Орос-Монголын рэвлэлийн хорооны үсэг хянагч зэрэг албыг нэгэн үе хашиж байна.

² О.Пүрэв. Ардын засгийн анхны ерөнхий сайд. УБ., 2001. т.8-9.

³ МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд (Сийрүүлж нэмсэн хоёр дахь хэвлэл). УБ., 2004. т. 205.

⁴ Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. (Хоёр дахь удаагийн хэвлэл). УБ., 1979. т. 12,14.

⁵ Мөн тэнд. т. 42.

ардын ба намын нэртэй” хэмээн ихэд эрхэмлэж байсан тухай Лосолын ярьсаныг Ө.Бадрах номдоо тэмдэглэжээ¹.

в.1920 оны хавар Монголын улс төрийн байдалтай танилцахаар Хүрээнд зориудаар ирсэн И.Сороковиковтай намын нөхдийн дотроос анх уулзсан хүн нь Бодоо байв. Хүрээн дэхь оросын “Хувьсгалт хороо”-ны нөхдийн зөвлөсөнөөр, Х.Чойбалсангаар хэлмэрчлүүлэн уулзсаны дараагаар тэрбээр өөрсдийн зорилгыг илүү тодорхой тайлбарлан таниулж, ЗОУ-аас тусламж горилж буйг илтгэн хэлэхийн тулд хоёр бүлгийн гишүүдийн дотроос 4 хүний (Х.Чойбалсан, М.Дугаржав, Д.Юмтаров, Жигмиддорж-Н.Х) хамтаар дахин Сороковиковтой уулзжээ. Чухамхүү энэ уулзалтын дараагаар ЗОУ-аас тусламж гуйх асуудал бүтэх тийшээ хандаж, улмаар хоёр бүлэг “МАН” хэмээх байгууллагад нэгдсэн хурлаас ЗОУ-д төлөөлөгч илгээх явдлыг албан ёсоор шийдэгдсэн билээ.

Хоёр. ЗОУ-д одсон МАН-ын төлөөлөгчдийн хоёрдахь хэсэгт Д.Бодоо, Д.Чагдаржав нар явсан билээ. Тэдний аян замын тухай баримт сэлт ихээхэн хомс бөгөөд гагцхүү түүхч, дэд эрдэмтэн Д.Даш Богдын тамга даруулахаар өгсөн бичгийн орос орчуулгад тавигдсан “цагаан бичин жилийн зургаан сарын 11” буюу аргын 1920 оны VII сарын 26-ныг эш болгон, Бодоо нарыг Хүрээнээс мөн сарын 27/28-нд гарсан² гэж бичсэн байдаг.

Энэ удаад ч мөн, намын нөхөд ЗОУ-аас тусламж гуйх бичгийг үйлдсэн даруйдаа тамга даруулахаар хөөцөлдсөн хэмээн үзэж “... бичигт Богдын мутрын тамга даруулахаар бүтэн өдөр болсон, тэр тухай мэдээг Лосол маргааш өдөр нь Бодоо, Сүхбаатар нарт хүргэсэн, мөн өдөртөө дээрхи нөхөд Жамъянгийн гэрт дахин хуралдаж, төлөөлөгчдийг өнөө маргаашгүй явуулахаар болсоны маргааш нь Д.Бодоо, Д.Чагдаржав нар явсан”³ гэж бичсэнийг эш болговол тэдний Хүрээнээс гарсан өдөр нь VII сарын 29-нд таарч байна. Энэ нь Даш агсаны хэлсэн өдрөөс нэг хоногоор зөрж байгаа хэдий ч, эл хоёр өдрийн аль аль нь үйл явдал өрнөсөн цаг хугацаатай нилээд дөхүү болно.

Д.Бодоо, Д.Чагдаржав нар нь намын модон тамга, нууц үгийн товч⁴-ийг авч явсан бөгөөд наймдугаар сарын эхээр Троицкосавск хотноо хүрч очжээ. Тэд ЗОУ-ын ГХАК-аас Монголыг хариуцсан төлөөлөгчөөр томилогдсон О.И.Макстенектай уулзан, “Монголын ард түмэн ба гадаад Монголын Ардын намын төлөөлөгчдийн бичиг”-ийг гардуулсан байна. Энэ тухай хувьсгалын түүхийн ном зохиол, дурдатгалуудад тодорхой тэмдэглэсэн зүйл үгүй, зөвхөн “...Бодоо нар араас ирэх төлөөлөгчид Сүхбаатар, Догсом, Лосол нарт захидал үлдээгээд цааш явсан” хэмээн дурдсан байдаг хэдий ч тухайн үед Монголын үйл хэрэгт оролцож явсан В.И.Юдин “...хоёрдахь төлөөлөгчид Дээд Шивээг дайран өнгөрөхдөө Ардын намын нэрийн өмнөөс О.И.Макстенект өгсөн” хэмээн өөрийн дурсамждаа иш татан оруулсан⁵ ба уг бичгийг хэрхэн олж авсан тухайгаа ч мөн бичиэ үлдээсэн байдаг. Түүний бичсэнээр, хуулбар бичгийг түүнийг Монгол-Зөвлөлтийн цэргийн араас АТЗГ-ын гишүүдийн хамт Нийслэл Хүрээ явж байхад нь О.И.Макстенек өгсөн бөгөөд харин “... бичгийн монгол эх болон Монголын төлөөлөгчидтэй хийсэн ярианы тэмдэглэлийг Эрхүү дэхь ЗОУ-ын ГХАК-ын Сибирь ба Алс Дорнотын асуудал эрхэлсэн бүрэн эрхт төлөөлөгчийн газар илгээсэн”⁶ ажээ.

Тэрхүү хуулбарыг дэд эрдэмтэн Д.Даш “Монголын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх” номын хоёрдахь хэвлэлд хийсэн тайлбартаа В.И.Юдины эш татсан хэсгээр нь оруулж, мөн монгол хэлнээ орчуулан

¹ Ө.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүд лүгээ тэмцсэн амжилттай их гэмцлийн туршлага. УБ., 2001. т. 19.

² Ч.Чойбалсан нар. Нэр дурдсан зохиол. т. 293.

³ Мөн тэнд. т.75-77.

⁴ МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд... т.58.

⁵ Монгольский сборник.(Экономика, история и археология). М., 1959. с. 110.

⁶ Интернационалч найрамдлын үйлсэд хүчин зүтгэгсэд. УБ., 1971. т. 7.

нийтлүүлсэн билээ. Уг бичигт "... ард иргэдийнхээ нийгэм, эдийн засгийн төвшинг дээшлүүж эс чадсан феодалын хэмжээгүй эрхт ёсны байгуулал нь ард түмэнд хөнөөлтэй болохыг мэдсэн хэсэг хүн монголчуудын дотор байсан... эл хүмүүс нь ... Оросын хувьсгалын байлдан ололтын нөлөө, ялангуяа хятадууд Монголын автономит эрхийг устгасаны дараа ардчилсан бүгд найрамдах агуулга бүхий улс төрийн мөрийн хөтөлбөр боловсруулан, сэтгэлэг адил бүхий хүмүүсээр өөрсдийгөө хүрээлүүлж ... Монгол орны бие даасан байдлыг сэргээхэд Зөвлөлт Орос улсаас тусламж олохоор шийдсэн билээ"¹ гэх зэргээр өгүүлсэн нь Монголын анхны тогтмол хэвлэлүүдэд нийтлэгдэж байсан зүйлүүдийн үзэл санаа давтсан гэмээр бөгөөд бас "Ардын нам"-ыг нилээд онцолсоноос үзвэл бичгийг Д.Бодоогийн үзэл бодол, үйл ажиллагаатай холбож болох мэт.

Бодоо, Чагдаржав Троицкосавст төдий л удалгүй цааш явж Дээд -Үдэд хүрсэн бөгөөд улмаар тэнд байсан Данзан, Чойбалсан, араас очсон Сүхбаатар, Догсом, Лосол нартай нэгдэн Эрхүүг зорьжээ. МАН-ын төлөөлөгчид VIII сарын 18-нд Эрхүү хотноо ирсэн бөгөөд галт тэрэгний буудлаас тэдэнд зориулан бэлтгэсэн "Амурское подворье" хэмээх буудалд буужээ. 19-ний өдөр ЗОУ-ын ГХАК-ын Сибирь ба Алс Дорнотыг хариуцсан төлөөлөгч Ф.И.Гапон болон Монгол-Төвдийн хэлтсийн ажилтнуудтай уулзсан бөгөөд уулзалт хотын гарнизоны Офицеруудыг ордонд болжээ². Өгүүлэн буй үеийн Д.Бодоогийн үйл ажиллагааг бусад нөхдийн үйл ажиллагаанаас ангид салган авч үзэх нь зохисгүй хэдий ч зарим зүйлийг баримт түшин онцлох нь чухал.

Юуны өмнө тэрбээр Эрхүү хотноо очсон даруйд буюу 1920 оны VIII сарын 20-нд ОК (б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн Монгол-Төвдийн хэлтсийн Коллегийн захион байгуулах хуралдаанд Х.Чойбалсангийн хамтаар оролцжээ. Коллегийн тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн, хэлтсийн ажилтнуудын ажил үүргийг хувиарлах асуудлыг хэлэцсэн уг хуралдаанаас Сүхбаатар, Х.Чойбалсан нарыг ухуулга сурталчилгаа, хэвлэлийн ажил эрхлэх дэд хэлтсийн ажилд татан оролцуулахаар тогтож, Х.Чойбалсанд коллегийн гишүүний эрх олгохоор шийдвэрлэн хэрэгжүүлжээ³. МАН-ын төлөөлөгчдийн дотроос Чойбалсанг тийнхүү сонгосон нь тэрбээр орос хэлийг бага зэрэг мэддэг байсныг харгалзсан хэрэг хэдий ч, хуралд хамт оролцсон "хуурай ах" Д.Бодоо ч бас түүний нэрийг дэвшүүлсэн байж болох талтай.

Д.Бодоогийн Эрхүүгийн үйл ажиллагааны хамгийн чухал зүйл нь тэрбээр Д.Догсомын хамтаар хоёр ч баримт бичгийг боловсруулсан явдал мөн. Эрх чөлөөний тэмцэлдээ ЗОУ-аас тусламж олохоор ирсэн МАН-ын төлөөлөгчид Богд хааны мутрын тамгаар баталгаажуулсан Халхын лам ноёдын бичгийг авч очсон боловч, тэднийг хүлээн авсан Гапон нарын зүгээс уул бичигтэй танилцсаны дараагаар чухам Ардын намын зорилго зорилт, тусламжийн тоо хэмжээг тодорхойлсон бичгийг МАН-ын нэрийн өмнөөс бичихийг санал болгожээ. Энэ ёсоор уул бичгийг зохиох ажлыг Бодоо, Догсом хоёр гүйцэтгэж, "Дорно зүгийн олон улс ард лугаа холбогдох хорооны Монгол Түвдийн хэлтэст" хэмээн хаяглан 1920 оны VIII сарын 29-нд гардуулжээ. Уг бичгийн агуулга олноо тодорхой тул давтан иш татахыг түдгэлзэж, гагцхүү бичигт Гадаад Монголын Ардын намын төлөөлөгч Бодоо, Догсом хэмээн гарын үсэг зурсан⁴ байгааг онцлоё.

Үүний дараагаар тэд дахин нэгэн бичгийг боловсруулж Монгол-Түвдийн хэлтэст өргөсөн байна. 1920 оны IX сарын 1-ээр өдөрлөсөн уг бичигт Монгол

¹ Догсомын Бодоо . 1885-1922. (Хэлсэн, бичсэн зүйлийн түүвэр). УБ., 2001. т.12-13.

² Монгольские революционеры в Иркутске в 1920 году. Ирк., 1982. с.3-4.

³ РГАСПИ. Ф.495. оп.152. д.3. л.3. Заверенная копия.

⁴ Коминтерн ба Монгол. Баримтын эмхтгэл. УБ., 1996. т. 22.

газарт тохиолдсон зовлон зүдгүүрийг товчлон дурдаж, монголчууд Манжаас салж, тусгаар улсаа байгуулсан хэдий ч өмнөд, умард хөршүүдийн бодлого, түлхэлтийн улмаас өөртөө засах эрхтэй улс болж, улмаар тэрхүү автономит засгийг алдсан бөгөөд түүний улмаас Гадаад Монголын ард олонд учирсан хүнд байдлыг 9 зүйлээр тоочин өгүүлжээ¹. Бодоо, Догсом нараас намын үйл ажиллагааны эхэн үеийн эдгээр чухал баримт бичгүүдийг боловсруулсан явдлыг зөвхөн тэдний бичиг үсгийн боловсролтой холбох төдий бус, мөн үзэл бодлын төлөвшил, нийгмийн өмнө тулгарсан зорилтыг ойлгож, томъёолох өндөр чадвар, төлөөлөгчдийн дундах нэр хүнд зэрэг нилээд олон зүйлийн учир холбогдлоор, өргөн утгаар тайлбарлах нь зүйд нийцнэ.

Гурав. Бодоо, Догсом нар нь ЗОУ-д очсон МАН-ын төлөөлөгчдийн дотроос Эрхүү хотноо хамгийн бага хугацаанд байсан хэдий ч харийн эрхшээлээс ангижрах тэмцлийн программын шинж чанартай бичиг баримтыг боловсруулж, улмаар практик зорилтыг гүйцэтгэхээр Хүрээнд буцжээ.

1920 оны VIII сарын 24-ны өдөр Эрхүү хотноо хуралдсан МАН-ын төлөөлөгчдийн зөвлөлгөөний баримт бичгийн 3-рт заасан ёсоор Бодоо, Догсом нар нь "... харъяат намын тоог олон болгох ба хүчнийг зузаатгах, цэрэг ангийг хуралдуулан элсүүлэх ба заасан газарт дайчлан илгээх, зэвсэг зүйлийг хүлээн авахуулах, чухал мэдээг харилцан мэдэлцэж тухай бүрд гүйцэтгэн шийтгэх, олон газраа төлөөлөгчдийн ангилан суулгах, дээрд доордын санал авч харилцан хэлэлцэх, басхүү намын тангаргийг бичиг дэвтэрт хэвлэн дэлгэрүүлэх, харъяат намын өнө үүрдийн байдал, суртал зарлалыг тогтоон хүмүүжүүлэх ба оньс арга, хүчин чадлыг ил далд бэлтгэх² зэрэг найман зүйлийн үүрэг хүлээжээ. Үүний зэрэгцээгээр ОК (б)Н-ын Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн зүгээс тэдэнд бас нэгэн яаралтай даалгаврыг өгсөн нь Монгол дахь хувьсгалт хөдөлгөөнийг удирдан зохион байгуулах боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор Эрхүү хотноо байгуулах цэрэг, улс төрийн сургуульд суралцуулах хүмүүсийг олж илгээх явдал байв. Энэ тухай баримтад "... ард олны доод давхраанаас, орос хэл жаахан ч атугай гадарлах 50 хүртэл залуусыг сургуульд элсүүлж, тэднийг Эрхүүд явуулах яаралтай даалгаврыг Эрхүүгээс Монголдоо буцаж очсон Ардын хувьсгалт намын гишүүд ба Өргөө дэхь тус хэлтсийн ажилтанд өгсөн"³ хэмээсэн нь Бодоо, Догсом, мөн тэдэнтэй хамт явсан Бегзеев буюу Ж.Цэвээнийг хэлсэн хэрэг юм. Бодоо нар ЗОУ-ын Москва хотноо тусламжийн асуудлыг эцэслэн шийдэхээр явах болсон төлөөлөгчдийн хэсэгт авч очсон Ардын намын тамгыг шилжүүлэн өгч, өөрсдөө Ж.Цэвээн, Баламсуу нарын хамтаар ёсдүгээр сарын эхээр Эрхүүгээс гарчээ.

Монгол дахь үндэсний хөдөлгөөн нийгмийн хувьсгал болон өргөжин гүнзгийрэх үндэс суурийг бэлтгэхээр явж буй эдгээр нөхдөд ОК(б)Н-ын Сибирийн товчооны зүгээс мөнгө санхүү, зэр зэвсгийн бодит тусламж өгсөн эсэх тухай асуудал сонирхолтой бөгөөд энэ талаар мэр сэр мэдээ буй. Тухайлбал, Д.Догсомын дурдатгалд "... Бодоо, Догсом нарт замын зардал болгон нилээд тооны орос цөлхөөв цаас туслан өгсөн", мөн "...тэд Хиагтад 48 ширхэг гар бөмбөг авч ирсэн"⁴ гэх зэргээр тэмдэглэсэн байдаг. Эл мэдээг тодотгох баримт орос хэл дээр бас байх бөгөөд тэдгээрийн заримыг ОХУ-ын Нийгэм улс төрийн түүхийн архиваас хуулбарлан авснаас доор иш татвал:

" Маш нууц. МАХН-ын бичиг хэрэгт. 1920.09.27. Баримт (Квитанция)

¹ Догсомын Бодоо... эмхтгэл. т.19-20.

² МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. т.162.

³ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт. (1920-1952). Баримтын эмтгэл. I боть. УБ., 2002. т. 20.

⁴ МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. т. 164,177.

Доор гарын үсэг зурсан н.Бодоо нь 4 хайрцаг гар бөмбөгийг хүлээн авсан тул энэхүү баримтыг өгөв. Троицкосавск хот. 1920 оны IX сарын 13. Бодоо. Хүлээлгэн өгсөн Макстенек хэмээн гарын үсэг зурж, "Хүрээн дэхь ГХАК-ын бүрэн эрхт төлөөлөгч" гэсэн үг бүхий тамга дарсан¹ бичиг байгаа нь "Бодоо нар гар бөмбөг авсан" асуудлыг давхар батлах бөгөөд чингэхдээ тэд Эрхүүгээс авсан зүйлийнхээ баримтыг Троицкосавскт ирсэнийхээ дараа өгчээ хэмээн үзэж болмоор байна.

Бодоо нарт мөнгө өгсөн асуудлыг тодотгох 2 баримт бас буй. Эхнийх нь Эрхүүгээс Дорно дахины ард түмний секцийн дарга Ф.И. Гапон, Монгол-Төвдийн хэлтсийн орлогч С.С.Борисов нарын гарын үсэгтэйгээр 159 гэсэн дугаартайгаар Троицковск дахь О.И.Макстенект ирүүлсэн цахилгаан утас бөгөөд түүнд: "...Бодоо, Бегзеев нар "романовка" хэмээх мөнгийг хэрхэн зарцуулж буй хийгээд 1000 доллар явуулах гуйлт хэнээс гарсан болохыг лавласан"² байна.

Хоёрдахь нь О.И.Макстенекийн хариу бөгөөд X сарын 13-нд, 422 дугаартайгаар, нууц шифрээр явсан уг цахилгаан утсанд "...хичнээн хэмжээний мөнгө зарцуулсан тодорхойгүй. Тэд Ванчиковоор дамжуулан 1000 доллар хүссэн"³ гэжээ. Үүнээс үзвэл, Монгол-Төвдийн хэлтэс нь Бодоо нарт замын зардлаас гадна тодорхой хэмжээний мөнгө олгосон нь тодорхой байна. Энэ нь монголчуудад тусламж үзүүлэх асуудлыг Төв шийдэхээс өмнө, Монголд дахь үндэсний хөдөлгөөнийг дэмжин өргөжүүлэхийн тулд ОК(б)Н-ын Сибирийн товчоо Хүрээнд буцсан МАН-ын төлөөлөгчдийн ажил төрөлд анхаарч, өөрийн эрхийн хэмжээнд зохих тусламжийг үзүүлэх болсоныг гэрчилнэ.

Д.Догсомын дурдатгалд тэмдэглэсэнээр Д.Бодоо нар нь Макстенекээс Хүрээний асууж мэдмэгц яаравчлан одохоор шийдсэн боловч, хятад цэргийн харуул манааг нэвтрэн гарахад бэрх тул тэнгэрийн байдлыг харгалзан, бороо хуртай шөнийн цагт хил гарахаар хэлэлцэж, 3 хоног хүлээсэн хэдий ч хур ороогүй тул 4 дэхь өдөр зүсээ хувилган, бас ч хэн нь эхлэн явахыг шодсоны эцэст Догсом эхлэн хил давж, араас нь Бодоо гарчээ.

Дөрөв. Төр түмний төлөө хүнд бэрхийг туулан намын даалгаврыг биелүүлэхээр явсан тэд Хүрээнд хүрмэгц Бодоогийн танил хэнгэрэгч лам Жамъянгийнд бууж, намын нөхөд Дэндэв, Галсан, Дугаржав нартай уулзаж, явсан хэргийн тухай айлтгал бичиж, Дэндэвээр уламжлуулан Богд гэгээнд толилуулсаны дараагаар түүний зөвлөсөн ёсоор Бодоо зүүн зүг явсан тухай түүхэнд өгүүлсэн нь олонтаа. Гэхдээ есдүгээр сарын дундаас хойш Хүрээнээс гарсан Бодоо хэдийд цагаан цэрэгтэй тохиолдон нийлж, чухам юу хийсэн нь төдий л тодорхой бус хэвээр үлдсэн байна.

Чойбалсан нарын зохиолд Бодоо нь Хүүхэн хутагтын хүрээнд сууж байгаад цагаантнаас нуугдах аргагүйд хүрч "... тэдэнд илээр дагаж ажил хийгээд далдуур барон нарын дотоод шинж байдлыг хянаж мэдэх арга хэрэглэж, өөрөө барон Унгернд гуйж ирж ороод дэргэдийн түшмэл бичээч мэтийн ажил хийсэн" ба Унгерн Хүрээг эзлэх үед хамт ирсэн гэж бичсэнийг хожмын түүхчид иш татан ашигласаар байгаа билээ. Энэ ч үнэн байх. Юутай ч атугай 1920 оны IX сарын 29-ний өдрийн Монгол-Төвдийн хэлтсийн мэдээнд Бодоог нутгийн гүн рүү явсан гэсэн⁴ бол 1921 оны I сарын 4-нд тус хэлтсийн эрхлэгч Э.Д.Ринчиногоос О.И. Макстенект бичсэн цахилгаан утандаа Бодоо, Догсом, Цэвээн нар хаана буйг асуусан байгаа⁵ нь Бодоо хэдий хугацаанд цагаантны дунд байсныг тодруулах нэгэн сэжиг болох юм.

¹ РГАСПИ. Ф.495.оп.154. д.30 л.20

² Мөн тэнд. л.145.

³ Мөн тэнд. лл.31-32.

⁴ РГАСПИ. ф.495. оп.152. д.3. л.20.

⁵ РГАСПИ. ф.495. оп.154. д.30. л.186-187.

Бодоо Хүрээнд буцаж ирсэний дараагаар намын нөхөдтэй уулзахдаа Унгерний бодлогын үнэн чанарыг тодорхой өгүүлэхийн хамт цагаантны дотор орчуулагчаар ажиллан, тусгай даалгавар гүйцэтгэж явсан Д.Юмтароваас Хиагт дахь намын нөхдөд чухал хэрэгцээтэй мэдээ сэлтийг дамжуулан авсан¹ тухайгаа хэлсэн бөгөөд гагцхүү цагийн үеийн байдлаас шалтгаалан Хиагт явж чадахгүй байсан аж. Гэвч Хүрээний Их цэргийг хэргийг Бүгд ерөнхийлэн захиран шийтгэх жургааны яамны Гадаад хэргийн түшмэдийн алба хашиж байсан² түүнд Унгерний сэргээн босгосон Богдын засгийн газраас Их Орос улсын (ЗОУ-Н.Х) Гадаад хэргийн комиссарт явуулах бичгийг зайсан лам Ээндэнданзангийн хамт хүргэлцэх завшаан тохиосон³-оор тэрбээр Хиагт дахь нөхөд дээрээ очих боломжтой болжээ.

Богдын засгийн газрын тэрхүү ноот бичгийг хүргэсэн хийгээд хариу уламжлан ирүүлэхэд Бодоогийн оролцоо хир зэрэг байсныг харуулахын тулд зарим нэгэн баримтыг иш татан дурдвас: Олноо өргөгдсөний 11-р он, цагаан сарын 25 буюу аргын 1921 оны III сарын 4-ний үед үйлдсэн уг ноот бичгийг хүргэхээр Бодоо, Ээндэн, Батхаан нарын хамтаар "... III сарын 6-нд Хүрээнээс гарч 11-нд Мензенскт⁴ ирж, Оросын хилийн харуулын комиссар дарга нартай уулзан захидлыг өгөхийн хамтаар Унгерний хүн хүч, зэвсэг хэрэгсэл, бодлого зорилгын тухай маш дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн"⁴-ийг үндэслэн оросын тал түүнийг "... 1920 онд МАН-ын төлөөлөгчөөр ЗОУ-д очиж байсан, одоо Монголын засгийн газрын зохих хэсгийн заавраар мэдээ хүргэж оросын нутаг дэвсгэрт ирсэн, итгэл даах хүн" гэж тодорхойлсон байна. Дашрамд тэмдэглэхэд эдгээр мэдээ нь монголын түүхийн зохиолууд болон ЗОУ-ыг тухайн үеийн тогтмол хэвлэлийн мэдээгээр ч бас давхар нотлогддог.

Бодоо нар нь бичгийг зохих албаны хүмүүст дамжуулсаны дараагаар, III сарын 14-16-ны орчим Хиагтад очсон байсан хэдий ч хариу ноотыг явуулах тухай асуудалд мөн л түүний нэр холбогдож байна.

Монголын засгийн газрын ноотын хариуг найдвартай хүнээр, амаар өгөх тухай удирдамжийг ЗОУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринээс Монголын асуудлыг хариуцаж байсан Б.З.Щумяцкийд өгсөн⁵ бөгөөд тэрхүү илгээлтийн агуулгыг ГХАК-ын орлогч Л.М.Карахан Монгол-Төвдийн хэлтсийн эрхлэгч Ринчинод хүргүүлжээ. Түүнийг Ринчино дагалдах зааврыг хавсарган IY сарын 5-ны өдөр, Троицкосавскт суусан Борисовт цахилгаан мэдээгээр нэвтрүүлсэн байна. Түүнд "... тус мэдээний агуулгыг Бодоод танилцуулж, түүнээс Хутагтад өгөх ноотыг хүргэх найдвартай хүнийг олж өгөхийг гуйх"⁶ хэмээн тов тодорхой заасанаас үзвэл ноотын хариуг цааш дамжуулан илгээх ажлыг Бодоод хариуцуулахаар шийдсэн нь харагдана. Үнэхээр ч тухайн хэрэгт Бодоогоос өөр хүнийг сонгох шаардлага төдий л байгаагүй гэлтэй бөгөөд, тэрбээр "хоёр нөхрийн хамт Монголын засгийн газрын ноотыг анхлан авчирсан, мөн "итгэл даах хүн" хэмээн үнэлэгдсэний хувьд ч тэр, аль аль талаараа уг ажлыг гүйцэтгэхэд тохирч байсан хүн юм. Харин, Бодоогийн олох ёстой "найдвартай хүн" бол Ээндэнзайсан байсан бөгөөд түүнийг Бодоо Хүрээнд буцаан илгээсэн тухай түүхийн баримт цөөнгүй бий. Энэ тухайгаа ч Бодоо өөрөө, АТЗГ-ын даргаар ажиллах болсон үедээ (11р он, хаврын сүүл сарын

¹ УТА. ф.1. д.2. хн.600.хуудас 17-22.

² Л.Бат-Очир. Бодоо сайд: үзэл ба үйлс. УБ., 1991.т.9.

³ Н.Магсаржав.Монгол улсын шинэ түүх. УБ., 1994. т.198.
- Мензенскс- Минж харуулын харалдаах Оросын цэргийн харуулын цэг.

⁴ Энэ тухай АДБНУ-ын Ардын хувьсгалт цэргийн Улс төрийн газрын Мэдээлэх товчооны 0021 тоот мэдээнд тэмдэглэгээнийг -// Догсомын Бодоо...// эмхтгэлийн 140-р талаас дам иш татав.

⁵ Барон Унгерн в документах и мемуарах .(Составитель и редактор С.Л.Кузьмин). М., 2004. с.627.

⁶ АВПРФ. Ф. 0111.оп.2. п.103.д.28.п.169 -// Барон Унгерн в документах и мемуарах // . М., 2004. с.106 -аас иш татав.

шинийн 5 буюу аргын 1921 оны IV сарын 13-ны орчим-Н.Х) "Халхын ван гүн, лам нарт" хэмээн хаяглаж Хүрээний засгийн газарт явуулсан захидалдаа бас дурдсан байдаг¹. Ийнхүү Монголын ард түмэнд эрх чөлөө олгох их хэргийг үүсгэн, амь биеийг үл хайрлан хүчин зүтгэсэн Д.Бодоогийн үйл ажиллагааны нэгэн зурвас үеийн тухай товчлон өгүүлсэнийг тегсгөн, дээр дурдсан зүйлүүд нь "агуулга баян, амьд түүхийг бүтээх"-эд дуслын төдий ч нэмэр болох болов уу хэмээн найднам.

Abstract: In this article, the author has studied the activities of Bodoо, one of the leaders of the Mongolian Revolution of 1921, from the time when "the Consul Group" was established to the beginning of March 1921 when he arrived in Khyakhta. Also, some peculiar features and date of some events related to the Revolution were made clear by the author.

Ном зүй

1. Барон Унгерн в документах и мемуарах (Составитель и редактор С.Л.Кузьмин). М., 2004
2. Ө.Бадрах. Намаас баруун беерөнхийчүүд лүгээ тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага.УБ., 2001
3. Л.Бат-Очир. "Д.Бодоо сайд: үзэл бодол, үйлс". УБ., 1991
4. Мөн түүний. Түүхэн үнэний эрэлд. (Судалгааны өгүүллийн түүвэр). УБ.,1999
5. "Догсомын Бодоо. 1885-1922. (Хэлсэн, бичсэн зүйлийн түүвэр)". УБ., 2001
6. Интернационалч найрамдлын үйлсэд хүчин зүтгэгсэд. УБ., 1971
7. Коминтерн ба Монгол. Баримтын эмхтгэл. УБ., 1996
8. Н.Магсаржав.Монгол улсын шинэ түүх. УБ., 1994
9. МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. (Сийрүүлж нэмсэн хоёрдахь удаагийн хэвлэл). УБ., 2004
- 10.Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт. (1920-1952). Баримтын эмтгэл. I боть. УБ., 2002
11. Монгольские революционеры в Иркутске в 1920 году. Ирк., 1982
- 12.Монгольский сборник.(Экономика, история и археология). М., 1959
13. О.Пүрэв .Ардын засгийн анхны ерөнхий сайд. УБ., 2001
14. РГАСПИ. Ф.495. оп.152. д.3
- 15.РГАСПИ. Ф.495.оп.154. д.30
- 16.УТА. ф.1. д.2. хн.600
- 17..Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх (Хоёр дахь удаагийн хэвлэл). УБ., 1979

¹ Догсомын Бодоо ... эмхтгэл. Т. 26.